# ХЭНТИЙ АЙМГИЙН
# НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 06 өдөр — Дугаар А/09 — Жаргалант

2025 оны цэргийн бүртгэл
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/675 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны цэргийн бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 06-ний өдрөөс 01 дугаар сарын 20-ний өдрүүдэд сумын хэмжээнд зохион байгуулж явуулсугай.

2.Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч | Х.Баасансүрэн | Тамгын газрын дарга |
| Нарийн бичгийн дарга | Б.Сумъяа | Төсөв төрийн сангийн мэргэжилтэн |
| Гишүүдэд | Х.Амарбаясгалан | Баян-Өлзийт багийн Засаг дарга |
| | А.Уранчимэг | Ангирт багийн Засаг дарга |
| | Э.Бат-Орших | Онон багийн Засаг дарга |
| | Г.Оюунчимэг | Жаргалант багийн Засаг дарга |
| | Ч.Үржинбадам | Улсын бүртгэгч |

3.2024 оны жилийн эцсийн хүн амын тоотой тулган, цэргийн бүртгэлийн материал, мэдээ судалгааг маягтын дагуу үнэн зөв гаргахыг ажлын хэсэгт даалгасугай.

4.Цэргийн тоо бүртгэлийн материалыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хуваарийн дагуу тушаахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Баасансүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232401018

Боловсруулсан:
Хянасан:
Хувь 2
Огноо: